

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
2.8.1 Мөнгөн хөрөнгө	11
2.8.2 Авлага.....	11
2.8.3 Урьдчилгаа	12
2.8.4 Бараа материал	12
2.8.5 Үндсэн хөрөнгө	13
2.8.6 Өр төлбөр	14
2.8.7 Засгийн газрын хувь оролцоо.....	14
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	15
2.11. Шилэн дансны мэдээлэл	16
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	16
3. Менежментийн захидал	17
3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	17
3.2 Балансын данстай холбоотой асуудал	17
3.3 Бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал	18
3.4 Балансын данстай холбоотой асуудал	18
3.5 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл	19
3.6 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл	19
3.7 Аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	20
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	21
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	22
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	23
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	24
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	25
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	27
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭСЯ	Элчин сайд яам
КГ	Консулын газар
ЕКГ	Ерөнхий консулын газар
БТГ	Байнгын төлөөлөгчийн газар
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам
УБХТГ	Улаанбаатар хот төлөвлөлтийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХШУДАГ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЖМС	Жижиг мөнгөн сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ДАВААСҮРЭН ТАНАА

2020.03.25 № 01/929
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн эрх зүйн актыг хэрэгжүүлэх, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх сайжруулах, холбогдох ЗГ-ын тогтоол, Сангийн сайдын журмыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 9-өөс 2020 оны 3 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор П.Чанцалдулам гүйцэтгэв.

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 08/1259 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан. Дипломат төлөөлөгчийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчныг бүрдүүлэх, дэлхийн улс орнуудтай бодит харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхдээ Дипломат төлөөлөгчийн газрууд нь Дипломат албаны тухай хуулийн хүрээнд Монгол Улсын гадаад харилцааг Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, хоёр ба олон талын харилцааны асуудлаар хэлэлцээ хийх, гэрээ хэлцэл байгуулах, тохиролцсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгаа хийх, холбогдох байгууллагад танилцуулах, хилийн чанадад Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах, гадаадад суугаа Монгол Улсын иргэдэд консулын болон нотариатын үйлчилгээ үзүүлэх, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хөтлөх үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл: Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дах монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хилийн чанадад хамгаалах зэрэг болно.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй бөгөөд уг бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь нягтлан бодогч нарыг

нэгдсэн арга зүйгээр хангах аргачлал дутмагаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх зэрэг сөрөг үр дагавартай байна.

Дипломат төлөөлөгчийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ТШЗ нь Санхүүгийн тооцоолох группын “Acoulous” программ хангамжийг ашигладаг бол санхүүгийн нэгтгэсэн тайланг Э-тайлангаар нэгтгэж байна.

Дипломат төлөөлөгчийн газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дипломат төлөөлөгчийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан батлуулж, Швейцарын Холбооны Улсад суугаа ЭСЯ, Шведийн Хаант Улсад суугаа ЭСЯ, Итали, Франц, Кувейт, Сингапур, Япон Улсад суугаа ЭСЯ, БНСУ-ын Пусан дахь консулын газар, Хонконг, Макао суугаа ЕКГ, Туркийн Истанбул хотод суугаа ЕКГ-уудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, илэрсэн зөрчлийг арилгах, цаашид зөрчилгүй ажиллах талаар холбогдох газруудад зөвлөмж өгч, ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын зааварлах захидлыг боловсруулж, дипломат төлөөлөгчийн газруудад хүргүүлжээ.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дипломат төлөөлөгчийн газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 23 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 43,931.6 сая төгрөгийн 1 хувь буюу 439.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 1,172.7 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх суурь үзүүлэлт буюу санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 117,268.5 сая төгрөгөөс 1 хувиар тооцсонтой холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 43 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,672.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,531.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 117.8 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 159.0 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 864.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүлээ.

Тайлант онд Монгол Улсаас гадаад оронд суугаа 18 ЭСЯ, 6 Ерөнхий консулын газар, 2 Байнгын төлөөлөгчийн газрын 2017 оны сүүлийн хагас жил, 2018 он, 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн тайлангийн аудит хийгдэж аудитаар дараах анхаарал татахуйц асуудлуудад анхаарал хандуулахыг ГХЯ-ны удирдлагуудад зөвлөсөн байна. Үүнд:

- Монгол Улсаас гадаад оронд суугаа ДТГ-уудын өөрийн эзэмшлийн байруудын ашиглалтыг сайжруулахад зориулсан төсөв хөрөнгийн асуудлыг ээлж дараатай шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах,
- Аудитын явцад хийсэн судалгаагаар зарим орны хувьд автомашиныг түрээсээр ашиглах нь улсын төсөвт дарамт багатай, эдийн засгийн ач холбогдолтой байх нөхцөлийг судлах,
- ДТГ-ын ажилтнуудын хувийн эзэмшлийн автомашинд олгосон дипломат дугаарын олголт, бүртгэлд тавих хяналтыг сайжруулах,
- ДТГ-ын ажилтнуудын цалин тогтоох нэгжийг холбогдох хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах,
- Аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлууд нь өргөн тархацтай, эрсдэл үүсгэж байгаа ДТГ-уудын үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх,
- Гадаад харилцааны яамнаас ДТГ-дад ашиглах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, арга зүйгээр хангаж мөрдүүлэх,
- Монгол Улсаас гадаад оронд суугаа ДТГ-т ажиллах дипломат ажилтнуудын “албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулж, мөрдөх, дипломат албан тушаал эрхлэх болзол болон мэргэжлийн бэлтгэл хангасан албан тушаалтныг томилж байх,
- Гадаад оронд суугаа ДТГ-уудаас Монгол Улсад зорчих виз олголтод байнгын хяналт тавих цахим мэдээллийн системтэй болох,
- ДТГ-уудад эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх, үр дүн, үр өгөөжийг тооцож ажиллах.

Аудитаар нийт 22,229.6 сая төгрөг буюу 8,408.6 мянган ам.долларын алдаа, зөрчил илрүүлж, 533.0 сая төгрөг буюу 201.6 мянган ам.долларын алдааг аудитын явцад залруулж, 1,548.1 сая төгрөг буюу 585.6 мянган ам.долларыг улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 13,259.6 сая төгрөг буюу 5,015.6 мянган ам.долларын алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох ДТГ-дад 21, Гадаад харилцааны яаманд 3, ТӨБЗГ-т 1 албан шаардлага хүргүүлж, 6,888.9 сая төгрөг буюу 2,605.8 мянган ам.долларын алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах нийт 127 зөвлөмж өгсөн байна.

Үүнээс 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудитаар нийт 1,497.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 181.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 357.3 сая төгрөгийг улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 421.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, 510.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах нийт 41 зөвлөмж өгч, 26.9 сая төгрөгийн ажил гүйлгээг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитаар Гадаад оронд суугаа ДТГ-т тогтоосон 357.3 сая төгрөгийн актыг бүрэн барагдуулсан, 421.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг 78 хувьтай биелүүлж, 41 зөвлөмж өгснөөс 28 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 73 хувьтай байна.

Аудитад Монгол Улсаас гадаад оронд суугаа ЭСЯ 18, Ерөнхий консулын газар 6, БТГ 2 хамрагдсанаас 15 ДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 10 ДТГ-ын тайланд “Хязгаарлалттай”, 1 ДТГ-ын тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Үүнд:

САГ-2020/17/СТА-ТТЗ

А. “Зөрчилгүй” дүгнэлт /*Будапешт, Бишкек, Бээжин, Вена, Женев, Канберра, Оттава, Стокгольм, Улаан-Үүд, Сөүл, Токио, Осака, Кызыл, Кувейт, Пхеньян*/;
Б. “Хязгаарлалттай” дүгнэлт /*Вашингтон, Гавана, Дели, Кайр, Сингапур, Лондон, Нью-Йорк, Пусан, Москва, Эрэн*/

В. “Сөрөг” дүгнэлт /*Хөх хот / өгсөн байна.*

ДТГ-уудын дотоод хяналт хангалтгүйгээс өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчил давтагдсан, ГХЯ-ны ХШУДАГ нь үйл ажиллагааны цар хүрээ ихтэй, хөрөнгийн маргаантай болон эрсдэлтэй газруудад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гадаад харилцааны яамны Санхүү, эдийн засгийн хэлтсээс гадаад оронд суугаа ДТГ-ын нягтлан бодогч нарт өгөх сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө, санхүүгийн бүртгэл, тайлагналд тавих хяналт хангалтгүйгээс санхүүгийн тайланг өмнөх оны үзүүлэлттэй зэрэгцүүлэхүйц хэлбэрээр гаргаагүй, тодруулга тайлангууд, төсвийн гүйцэтгэлийн тохируулга тайлан бэлтгээгүй, улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг буруу тайлагнадаг, хөрөнгө, бараа материалын тайлангийн үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлдэг зөрчлүүд арилахгүй давтагдсан байна.

Дипломат төлөөлөгчийн газрууд нь Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний дотор хүргүүлэх байсан боловч хангалтгүй ирүүлсэн, ГХЯ-ны ХШУДАГ нь уг биелэлтийн хэрэгжилтийг гаргуулж, нэгтгэлийг хийж, үнэлээгүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гадаад оронд суугаа дипломат төлөөлөгчийн газруудын аудитаар өгсөн акт, албан шаардлагын биелэлтийг хянахад нийт тогтоосон актын 84.9 хувь буюу 1,315.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн, үндсэн хөрөнгө, дахин үнэлгээний дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн, төсөвт зардлыг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч зарим зардлуудыг батлагдсан төсөвт зардлаас хэтрүүлсэн зэрэг 2,239.7 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, ТӨБЗГ-ын шийдвэрээр хөрөнгө актлаагүй, акталсан боловч ашиглаж байгаа үндсэн хөрөнгө, бараа материалыг залруулж бүртгэх зөвлөмж өгсний дагуу ТӨБЗГ-ын 2017 оны 498, 2019 оны 451, 31, 32 дугаар тогтоол, 2019 оны А-2/2227, А-1/4155 албан бичгээр зөвшөөрөл авч, холбогдох хөрөнгийн хөдөлгөөнийг хийж ажилласан боловч албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 72.9 сая төгрөгөөр авлагыг илүү, 0.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг дутуу, 72.9 сая төгрөгөөр өр төлбөрийг илүү, Засгийн газрын оруулсан капиталыг 87.9 сая төгрөгөөр илүү, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг 248.8 сая төгрөгөөр илүү, 165.5 сая төгрөгөөр тайлант оны үр дүнг дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 165.3 сая төгрөгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу, 0.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлыг илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капиталыг 87.9 сая төгрөгөөр илүү, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг 248.8 сая төгрөгөөр илүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг 171.4 сая төгрөгөөр илүү, 165.5 сая төгрөгөөр тайлант оны үр дүнг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 8.5 сая төгрөгөөр бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, ахуйн эд зүйлсийн зардлыг илүү, 46.3 сая төгрөгөөр гадаад валютын ханшийн зөрүүний гарзыг илүү, 54.8 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан хөрөнгийн зардлыг дутуу нэгтгэсэн;

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 8.5 сая төгрөгөөр бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, ахуйн эд зүйлсийн зардлыг илүү, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих орлогыг 55.3 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Нэгтгэгдсэн байгууллага хооронд болон ДТГ-ын хооронд үүссэн 72.9 сая төгрөгийн өглөг, авлага, 1,152.8 сая төгрөгийн давхардсан орлого болон зардлын ажил гүйлгээний устгах бичилтийг дутуу тайлагнажээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Женев дэх Байнгын төлөөлөгчийн газар нь үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто машиныг ТӨБЗГ-ын 2019 оны 541 дүгээр тогтоолоор данс бүртгэлээс хасаж, худалдан борлуулсны орлого 1,000.0 ам долларын орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй, түрээсээр худалдан авах автомашины лизингийн урьдчилгаа төлбөрт зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", ТӨБЗГ-ын 2019 оны 541 дүгээр тогтоолыг тус бүр зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэлгүй, түрээсээр худалдан авах автомашины лизингийн урьдчилгаа төлбөрт зарцуулсан төлбөр 1000 ам.доллар буюу 2.7 сая төгрөгт акт тогтоох

ДТГ нь цалин хөлс, нийгмийн даатгалын зардлаас хувь хүний орлогын албан татварт 104.6 сая төгрөгийг Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст, 10.5 сая төгрөгийг Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст тус тус илүү тооцон шилжүүлж, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд авлага нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож шилжүүлсэн ХХОАТ-ын 104.6 сая, НДШ-ын 10.5 сая, нийт 115.1 сая төгрөгийг улсын төсвийн орлогын дансанд татан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох;

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 1,651.1 сая төгрөгийн 10 жилийн өмнө үүссэн тодорхойгүй авлагын үлдэгдэл байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулах, барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэх;

Тайлант онд ДТГ-ын багцын дүнгээр батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч Нью-Йорк дахь БТГ 3.6 мянга, Женев дэх ЭСЯ 17.4 мянга, Парис дахь ЭСЯ 38.6 мянган ам.доллараар буюу нийт 159.0 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлж үйл ажиллагааны орлогоос зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт гаргаж байх албан шаардлага хүргүүлэх;

Төсвийн төвлөрүүлэн захирагчид 864.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 7 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,776.8 сая, эцсийн үлдэгдэл 4,703.8 сая төгрөг болж, 927.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Касст байгаа бэлэн мөнгө	686.4	507.2	(179.2)	(19.3)
Төгрөг	-	6.9	6.9	0.7
Гадаад валют	686.4	500.3	(186.1)	(20.1)
Банканд байгаа бэлэн мөнгө	2,609.7	1,944.6	(665.2)	(71.8)
Төгрөг	-	169.3	169.3	18.3
Гадаад валют	2,609.7	1,775.3	(834.5)	(90.0)
Замд яваа мөнгөн хөрөнгө	480.7	2,252.0	1,771.4	191.1
Хадгаламж				
Дүн	3,776.8	4,703.8	927.0	100.0

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 507.2 сая төгрөг касст, 1,944.6 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 1,849.0 сая төгрөг Москва дахь ЭСЯ-ны барилгын их засварын зардлын санхүүжилт, Дели, Прага, Камберра дахь ЭСЯ-ны 146.0 сая, Эрээн, Бишкек дэх ЕКГ-ын 257.0 сая, нийт 403.0 сая төгрөг нь харилцах данснаас улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

ДТГ-ын кассад 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 507.1 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэл тайлагнагдсанаас 317.8 сая төгрөг нь "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6-д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийн байгууллагын кассад хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна", 6.2-т "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс хамааран хамгийн ихдээ 1,500.0-3,000.0 мянган төгрөгийн хэмжээтэй байна" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Төсвийн зарцуулагдаагүй 317.8 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй Бангкок дахь ЭСЯ 17.7 сая, Оттава дахь ЭСЯ 89.8 сая, Парис дахь ЭСЯ 22.8 сая, Нью-Йорк дахь ЭСЯ 12.9 сая, Эрхүү дэх ЕКГ 25.7 сая, Эрээн дэх ЕКГ 23.3 сая, Шанхай дахь ЕКГ 54.2 сая, 4.4-7,8 сая төгрөг хүртэлх үлдэгдэлтэй 9 ЭСЯ-ны 71.4 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 4,034.8 сая, эцсийн үлдэгдэл 3,947.2 сая төгрөг болж, 87.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Ажиллагчидтай холбогдсон авлага	11.5	115.1	103.6	(118.2)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	315.3	-	(315.3)	359.9
Бусад авлага	3,708.0	3,832.1	124.1	(141.7)
Байгууллагаас авах авлага	3,308.0	3,417.9	109.9	(125.5)
Хувь хүмүүсээс авах авлага	400.0	414.2	14.2	(16.2)
Дүн	4,034.8	3,947.2	(87.6)	100.0

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 2.2 хувь буюу 87.6 сая төгрөгөөр буурсан боловч нийт авлагын үлдэгдлийн 44.7 хувь буюу 1,764.2 сая төгрөг нь тайлант онд шинээр үүссэн бөгөөд 1,330.7 сая төгрөг нь байрны барьцаа төлбөр, ажиллагсдаас авах авлага мөн НӨАТ-ын буцаан авалт байгаа бол 278.6 сая төгрөг нь БНСУ дахь ЭСЯ-ны худалдан авах гэрээ байгуулж, 2020 оны 2, 3 дугаар сард хүлээн авахаар авлагаар бүртгэсэн 2 ширхэг автомашины төлбөр байна.

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 1,697.0 сая төгрөгийн тооцоо нийлсэн актгүй авлага тайлагнагдсаны 97.3 хувь буюу 1,651.1 сая төгрөг нь 10 жилийн өмнө үүссэн тодорхойгүй авлагын үлдэгдэл байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 1,651.1 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Астана дахь ЭСЯ-д барилга, газрын маргаантай холбоотой 10 жилийн өмнө үүссэн 1,641.5 сая төгрөгийн авлага;
- Берлин дэх ЭСЯ-ны 2013, 2015 онуудад буцсан ажиллагсадтай холбоотой үүссэн 9.6 сая төгрөгийн авлага;

Эдгээр нь ДТГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын үлдэгдлийг өсгөх, эргэн төлөгдөхгүй, найдваргүй авлага болох эрсдэлтэй байгаад анхаарал хандуулж, уг авлагыг барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 115.9 сая төгрөг байгаа нь хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 36.0 сая, давсан орлогоос 79.9 сая төгрөгийг тус бүр Бээжин дэх ЭСЯ-ны Консулын хэлтсийн виз олгох хэсгийг өргөтгөх их засварын ажлын зардлын санхүүжилтийн урьдчилгаа байна.

2.8.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,347.1 сая, эцсийн үлдэгдэл 2,436.5 сая төгрөг болж, 1,089.4 сая төгрөгөөр өмнөх оноос өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Түүхий эд материал	110.2	958.3	848.2	77.9
Тусгай зориулалтын материал	110.2	958.3	848.2	77.9
Бэлэн бүтээгдэхүүн	5.4	15.2	9.9	0.9
Хангамжийн материал	1,231.5	1,462.9	231.4	21.2
Бичиг хэргийн материал	42.5	44.9	2.4	0.2
Аж ахуйн материал	68.2	108.0	39.8	3.7

Сэлбэг хэрэгсэл	49.3	74.0	24.7	2.3
Түлш, шатах тослох материал	3.2	31.1	28.0	2.6
Барилгын засварын материал	0.4	-	(0.4)	(0.0)
Хүнсний материал	194.8	200.0	5.2	0.5
Бусад хангамжийн материал	873.0	1,004.8	131.8	12.1
Дүн	1,347.1	2,436.5	1,089.4	100.0

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн өсөлтөд хамгийн их нөлөөлсөн данс нь тусгай зориулалтын материал бөгөөд тайлант онд ЗГНС-гаас зээл авч 1,153.9 сая төгрөгийн 1,000.0 мянган ширхэг визний хуудсыг Эвер волл Си Пи ЭС Монголиа ХХК-иар гүйцэтгүүлсэнтэй холбоотой үүсжээ.

Бусад хангамжийн материал 131.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь БНСУ дахь ЭСЯ-ны худалдан бэлтгэсэн 31.1 сая төгрөгийн засварын материал, Ханай дахь ЭСЯ-ны 18.7 сая, Москва дахь ЭСЯ-ны 15.4 сая төгрөгийн бусад хангамжийн материал худалдан авалтаас шалтгаалсан байна.

Түлш, шатах тослох материалын үлдэгдэл 31.1 сая төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 9.7 дахин буюу 27.9 сая төгрөгөөр өссөн нь Женев дэх Байнгын төлөөлөгчийн газрын 19.4 сая, Бээжин дэх ЭСЯ-ын 5.6 сая төгрөгийн шатахуун үлдэгдэл бөгөөд тайлант оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж, нөөцөлснөөс голлон шалтгаалжээ.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 370,303.1 сая, эцсийн үлдэгдэл 374,717.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4,414.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Газар	33,342.5	33,342.5	-	-
Биет хөрөнгө	312,804.7	317,220.5	4,415.8	100.0
Барилга, байгууламж, орон сууц	296,021.7	298,694.9	2,673.2	60.5
Авто-тээврийн хэрэгсэл	8,601.8	10,286.4	1,684.6	38.3
Машин тоног				
төхөөрөмж(компьютер)	2,989.5	3,164.8	175.3	3.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,879.0	4,736.7	(142.7)	(3.2)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1.4	1.4	-	-
Бусад үндсэн хөрөнгө	298.0	322.1	24.1	0.5
Ном	13.1	14.2	1.1	0.1
Биет бус хөрөнгө	24,155.9	24,154.8	(1.1)	(-0.1)
Програм хангамж	50.1	49.0	(1.1)	-
Бусад биет бус хөрөнгө	24,105.8	24,105.8	-	-
Дүн	370,303.1	374,717.8	4,414.7	100.00

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,967.5 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 416.9 сая, тооллогоор илэрсэн бусад хөрөнгө 420.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 456.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, ТӨБЗГ-ын тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн 165.3 сая, акталсан 1,681.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Тайлант онд худалдан бэлтгэсэн хөрөнгийн 2,803.4 сая төгрөгийг хөрөнгө оруулалтаас, 1,871.6 сая төгрөгийг нь үйл ажиллагааны давсан орлогоос санхүүжүүлсэн байна. Дээрх санхүүжилтээс 18 ЭСЯ-нд 1,737.4 сая төгрөгийн автомашин худалдан авч

парк шинэчлэл хийсэн, 8 ЭСЯ-ны их засварт 2,401.9 сая төгрөгийн сайжруулалт хийж, 4 ЭСЯ-д 538.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан бэлтгэжээ.

ТӨБЗГ-ын 2019 оны 31, 32, А/2/2227 тоот албан бичгээр 618.8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 523.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 537.5 сая төгрөгийн тавилга эд хогшил, 2.0 сая төгрөгийн программ хангамжийг акталсан байна.

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 643.3 сая, эцсийн үлдэгдэл 539.4 сая төгрөг болж, 103.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	643.3	539.4	(103.9)	100.0
Ажиллагсадтай холбоотой өглөг	24.8	0.0	(24.8)	23.9
Бараа үйлчилгээний бусад зардлын өглөг	0.0	11.4	11.4	(11.0)
Бусад өглөг	618.5	524.2	(94.3)	90.7
Байгууллагад төлөх өглөг	607.1	491.3	(115.8)	111.4
Хувь хүмүүст төлөх өглөг	11.4	32.8	21.5	(20.7)
Урьдчилж орсон орлого	0.0	3.8	3.8	(3.6)
Бусад урьдчилж орсон орлого	0.0	3.8	3.8	(3.6)
Дүн	643.3	539.4	(103.9)	100.0

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөгийн үлдэгдэл өмнөх оноос 16.6 хувь буюу 103.9 сая төгрөгөөр буурсан боловч нийт өр төлбөрийн үлдэгдлийн 77.4 хувь буюу 417.4 сая төгрөг нь тайлант хугацаанд шинээр үүссэнээс 85.4 сая төгрөг нь Брюссель дэх ЭСЯ-ны барилгын дотоод засал хийлгэх их засварын төлбөр, 43.4 сая төгрөг нь Санфранциско дахь ЭСЯ-ны давсан орлогоос хөрөнгө худалдан бэлтгэсэн төлбөрийн тооцоо бол 125.9 сая төгрөг нь 5 ЭСЯ-ны үнэт цаасны хэвлүүлсний төлбөрийн үлдэгдэл байна.

ДТГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд 3-с дээш жил болсон 60.7 сая төгрөгийн өглөг байгаа нь Итали дахь ЭСЯ-ны АСЕМ-ын үеийн гадны байгууллагад шилжүүлэх төлбөрийн үлдэгдэл байгаад анхаарал хандуулан ажиллавал зохиолтой байна.

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 353,522.1 сая, эцсийн үлдэгдэл 335,401.7 сая төгрөг болж, өмнөх оноос 18,120.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Засгийн газрын оруулсан капитал	189,945.6	189,945.6	-	-
Хуримтлагдсан үр дүн	-87,624.4	-92,652.9	-5,028.6	27.8
Өмнөх үеийн үр дүн	-59,868.2	-72,177.3	-12,309.1	67.9
Тайлант үеийн үр дүн	-27,756.1	-20,475.6	7,280.5	-40.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	251,200.9	251,200.9	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	-13,091.8	-13,091.8	72.2
Дүн	353,522.1	335,401.7	-18,120.3	100.0

Эх сурвалж: Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны үр дүн 12,309.1 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны санхүүгийн тайлангийн гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүг хаасантай холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсөв захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 64,672.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 61,860.9 сая төгрөгийг урсгал зардалд 2,811.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр 63,912.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,119.2 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

2019 оны төсвийн тухай хуулиар ТТЗ-ийн төвлөрүүлэх орлогын хэмжээг 20,000.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 22,394.1 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 2,394.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь визний хураамжийн орлого урьдчилж орсноос шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 7,904.5 сая төгрөгийг бүрдүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос 2,435.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд шилжүүлэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 60,598.6 сая төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь ДТГ-ын тэргүүн тайлант хугацааны дундуур томилогдсон, зарим орон тоо дутуу ажилласан зэргээс цалингийн зардал 1,878.2 сая, байр ашиглалтын зардал 495.8 сая, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн ажилтнууд үргэлжлүүлэн ажиллаж байгаагаас тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 233.1 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 225.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 425.6 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант онд ДТГ багцын дүнгээр батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч Нью-Йорк дахь БТГ 3.6 мянга, Женев дэх ЭСЯ 17.4 мянга, Парис дахь ЭСЯ 38.6 мянган ам.доллороор буюу нийт 159.0 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлж үйл ажиллагааны орлогоос зарцуулжээ.

Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээнд 2,811.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,803.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт төсөв: ЗГНС-гаас 3,578.2 сая, Тайпей дэх УБХТГ-ын санхүүжилт 620.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,435.6 сая, БСШУЯ-аас Пёньян дахь ЭСЯ-д 10.0 сая төгрөгийн хамтын ажиллагааны гэрээний санхүүжилт олгож, нийт 6,643.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Засгийн газрын тогтоолын дагуу 3,261.5 сая, хөрөнгийн зардалд 1,698.2 сая, үйл ажиллагаанд 1,198.1 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 316.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, нэмэлт санхүүжилтийн харилцахад 169.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дипломат төлөөлөгчийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар Улаанбаатар хотын төсвөөс Тайпей дэх УБХТГ-ын 620.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, холбогдох газарт дамжуулан шилжүүлсэн байгаа боловч анхан шатны баримттай танилцах боломжгүй байсан.

ДТГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 1,697.0 сая төгрөгийн тооцоо нийлсэн актгүй авлага бүртгэсний 97.3 хувь буюу 1,651.1 сая төгрөг нь 10 жилийн өмнө

үүссэн барилгын маргаан болон буцсан ажиллагсадтай холбоотой үүссэн тодорхойгүй авлага бүртгэлтэй байна.

2019 оны төсвийн тухай хуулийн дагуу ГХЯ-ны хөрөнгө оруулалтын харилцах дансанд ДТГ-ын 2,803.4 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт орж, үүнээс 1,703.6 сая төгрөг нь барилгын их засварт, 1,099.8 сая төгрөг нь 8 ЭСЯ-ны автомашин худалдан авалтад тус бүр санхүүжигдсэн байна.

Мөн 2019 оны үйл ажиллагааны давсан орлогоос ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 24-ний 635 дугаар тогтоолоор 12 ДТГ-ын 1,475.9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 7 ДТГ-ын 360.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах зөвшөөрөл авч ажил үйлчилгээг гүйцэтгэхдээ дээрх хөрөнгийн худалдан авалт, хөрөнгө нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг ТБОНӨХБАУХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэгт "..... Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрын худалдан авах ажиллагааг зохион байгуулахад төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхгүй байж болно" гэж заасны дагуу Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны 6-1/8597 тоот албан бичгээр холбогдох зөвшөөрлийг авсан байна.

Гэвч худалдан бэлтгэсэн хөрөнгийн санхүүжилтийг олгосон, хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл авсан хугацаа оны эцэст байгаа нь хөрөнгийг худалдан авах ажиллагаа нь холбогдох хууль, журмын дагуу явагдсан эсэхийг нягтлах боломжгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дипломат төлөөлөгчийн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 107 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бөгөөд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй нийт 471 ширхэг 59,799.5 сая төгрөгийн ажил гүйлгээг мэдээлжээ.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 505.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 210.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитаар залруулагдаагүй 1,140.9 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 1,172.7 сая төгрөгийн материаллаг түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өгч байна.

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дипломат төлөөлөгчийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

ГХЯ нь харьцуулалтын аргаар УБ Сонгодо эмнэлгийг сонгож, гэрээ байгуулан нийт 116 ажилтныг урьдчилан сэргийлэх багц шинжилгээ, үзлэгт хамруулсан боловч нийт 23.2 сая төгрөгийн төлбөрийг төлөхдөө нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас санхүүжүүлсэн нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын 2108, 2109 дэх эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Зориулалт бусаар зарцуулсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсөвт зардлыг Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын эдийн засгийн ангилалд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж байх;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт:

Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 77.4 хувь буюу 417.4 сая төгрөг нь тайлант хугацаанд шинээр үүссэнээс 85.4 сая төгрөг нь Брюссель дэх ЭСЯ-ны барилгын дотоод засал хийлгэх их засварын төлбөр, 43.4 сая төгрөг нь Санфранциско дахь ЭСЯ-ны давсан орлогоос хөрөнгө худалдан бэлтгэсэн төлбөрийн тооцоо, 125.9 сая төгрөг нь 5 ЭСЯ-ны үнэт цаасны төлбөрийн үлдэгдэл байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан

гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.2-т "Төсвийн жилд, эсхүл дараалсан хоёр улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар өр төлбөр үүсгэх", Батламж мэдэгдлийн *Тохиолдсон байх* “Аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтайгаар удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж, ажил гүйлгээний үлдэгдлийг баталгаажуулж, төлөх боломжтой өр төлбөрийг тайлант онд нь барагдуулж байх;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Гадаад харилцааны яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг нь 2013 онд боловсруулагдсан бөгөөд 2013 оноос хойш өөрчлөгдсөн хууль тогтоомж, Сангийн сайдын баталсан болон бусад батлагдсан заавар журмын өөрчлөлтийг тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэнтэй нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогийг тусгаж, шинэчлэн сайжруулах;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Балансын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Түлш, шатах тослох материалын үлдэгдэл 31.1 сая төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 9.7 дахин буюу 28.0 сая төгрөгөөр өссөн байна. Дээрх үлдэгдлээс 19.4 сая төгрөг нь Женев дэх Байнгын төлөөлөгчийн газар, 5.6 сая төгрөг нь Бээжин дэх ЭСЯ-ын шатахууны үлдэгдэл бөгөөд тайлант оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж, нөөцөлснөөс шалтгаалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэнтэй нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Дотоод хяналт сул байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүжилтийн үлдэгдлээр хөрөнгийн нөөц үүсгэхгүй, Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлж байх;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5 ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

3.5.1 Илрүүлэлт:

ДТГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 43 ДТГ-ын 121 авто машин тайлагнагдсан бөгөөд үүнээс Бээжин дэх ЭСЯ-д 8, Москва дахь ЭСЯ-д 10, Токио дахь ЭСЯ-д 7, Анкара дахь ЭСЯ болон Берлин дэх ЭСЯ-д тус бүр 5, Брюссель дэх ЭСЯ-д 6 автомашин бүртгэлтэй бол бусад ЭСЯ-д 1-4 хүртэлх автомашиныг бүртгэж тайлагнажээ. Нийт 121 автомашин бүртгэлтэйгээс 39 автомашин нь 2500 cc дээш хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжтай байгаа нь шатахууны зарцуулалт их, сэлбэг хэрэгслийн төлбөр үнэтэй байх нь улсын төсөвт зардал нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолын 2 ба 8 дугаар заалттай тус бүр нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Үр ашиггүй зардал гарах

3.5.3 Өгсөн зөвлөмж:

ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолын дагуу 2500 cc дээш хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжтай, шатахуун их зарцуулдаг авто машин худалдан бэлтгэхгүй, ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.6 ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

3.6.1 Илрүүлэлт:

ДТГ-ын кассад 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 507.1 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэл тайлагнагдсанаас 317.8 сая төгрөг нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6-д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийн байгууллагын кассад хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна", 6.2-т "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс хамааран хамгийн ихдээ 1,500.0-3,000.0 мянган төгрөгийн хэмжээтэй байна" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

3.6.2 Эрсдэл:

Кассын үлдэгдлийг тооллого хийгээгүй, тооллогын баримт зөрүүтэй байх, касс их хэмжээний мөнгөний гүйлгээ хийгддэг байх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдлийг жилийн эцэст улсын төсөвт бүрэн төвлөрүүлж, ЖМС-гийн хэмжээг 1,500.0-3,000.0 мянган төгрөг хооронд байгуулан зарцуулж байх;

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.7 Аудитын АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

3.7.1 Илрүүлэлт:

Гадаад оронд суугаа ДТГ-ууд нь Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 1-ний дотор хүргүүлэх байсан боловч хангалтгүй ирүүлсэн, ГХЯ-ны ХҮШДАГ нь уг биелэлтийг гаргуулж, нэгтгэлийг хийж, үнэлээгүй бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хянахад нийт 1,497.2 сая төгрөгийн зөрчлийг 85 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.7.2 Эрсдэл:

Дотоод хяналт сул байх, алдаа зөрчлийг дахин давтаж гаргах

3.7.3 Өгсөн зөвлөмж:

ХҮШДАГ нь аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төсвийн хуулийн хугацаанд гаргуулж, нэгтгэж, үнэлж, хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тооцож байх;

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,158,661.9	11,203,344.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,776,769.2	4,703,750.4
33	АВЛАГА	4,034,829.0	3,947,206.9
34	УРЬДЧИЛГАА	0.0	115,914.5
35	БАРАА МАТЕРИАЛ	1,347,063.8	2,436,472.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	345,006,744.6	324,737,774.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	345,006,744.6	324,737,774.9
39100	Газар	33,342,495.7	33,342,495.7
39200	Биет хөрөнгө	287,516,953.6	267,259,529.1
39300	Биет бус хөрөнгө	24,147,295.3	24,135,750.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	354,165,406.6	335,941,119.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	643,338.2	539,397.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	643,338.2	539,397.4
41300	Өглөг	643,338.2	535,612.2
41400	Урьдчилж орсон орлого	0.0	3,785.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	353,522,068.4	335,401,721.7
51	Засгийн газрын хувь оролцоо	353,522,068.4	335,401,721.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	189,945,563.1	189,945,563.1
51200	Хуримтлагдсан үр дүн	-87,624,358.3	-92,652,920.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	251,200,863.6	251,200,863.6
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	-13,091,784.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	354,165,406.6	335,941,119.0

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	85,786,046.6	96,478,031.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,256,187.5	28,100,581.4
120	Нийтлэг татварын бус орлого	24,256,187.5	28,100,581.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,529,859.1	68,377,449.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	94,069,665.8	116,667,404.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,464,740.4	116,586,109.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,118,264.7	85,680,900.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,887,603.1	25,396,144.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	614,639.8	550,291.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,127,001.1	13,307,531.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,063,059.1	2,117,676.6
2105	Нормативт зардал	12,257.3	9,222.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	928,242.0	710,737.2
2107	Томилолт, зочны зардал	4,540,828.8	4,155,156.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,094,499.6	7,965,330.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,850,133.9	31,468,810.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,346,475.8	30,905,208.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,604,925.4	81,295.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-8,283,619.2	-20,189,373.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	314,620.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,472,513.9	600,878.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-27,756,133.1	-20,475,632.2

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	85,408,471.3	98,938,124.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,693,708.9	27,863,070.6
120	Нийтлэг татварын бус орлого	24,693,708.9	27,863,070.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,714,762.4	71,075,053.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,211,817.1	90,989,577.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,211,817.1	90,989,577.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,550,008.1	60,084,368.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,221,113.8	24,832,919.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	607,201.9	550,291.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,195,510.8	13,456,004.1
2104	Хангамж, бараа материалын зардал	2,334,193.7	2,039,305.2
2105	Нормативт зардал	15,320.5	14,328.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	924,928.4	671,389.6
2107	Томилот, зочны зардал	4,380,708.6	4,138,967.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,489,678.1	8,308,069.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,381,352.4	6,073,093.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,661,809.0	30,905,208.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-803,345.8	7,948,546.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,450,000.0	5,932,028.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,450,000.0	5,932,028.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,450,000.0	5,932,028.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,450,000.0	-5,932,028.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-471,256.1	-1,089,537.7
14	Бусад эх үүсвэр	0.0	129,147.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	471,256.1	1,218,684.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-2,724,602.0	926,981.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,501,371.1	3,776,769.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,776,769.2	4,703,750.4

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,053,110.2	-	86,053,110.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,611,467.3	-	-7,611,467.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,441,642.9	-	78,441,642.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	251,200,863.6	-	251,200,863.6
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	82,940,479.6	-	82,940,479.6
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-16,109,185.8	-	-16,109,185.8
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-27,756,133.1	-	-27,756,133.1
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,522,068.4	-	353,522,068.4
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	353,522,068.4	-	353,522,068.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	251,470.9	-	251,470.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,969,138.1	-	368,969,138.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-13,091,784.2	-	-13,091,784.2
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-20,475,632.2	-	-20,475,632.2
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,401,721.7	-	335,401,721.7

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,672,332.6	60,598,628.7	4,073,703.9	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,860,932.6	57,795,251.8	4,065,680.8	93.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,521,107.7	57,688,515.9	3,832,591.8	93.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,358,961.9	24,480,759.1	1,878,202.8	92.9
210101	Үндсэн цалин	22,633,022.9	24,480,759.1	-1,847,736.2	108.2
210102	Нэмэгдэл	3,725,939.0	0.0	3,725,939.0	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	956,316.1	544,691.2	411,624.9	57.0
210201	Тэтгэврийн даатгал	956,316.1	544,691.2	411,624.9	57.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,770,772.7	13,274,929.1	495,843.6	96.4
210301	Гэрэл, цахилгаан	1,185,600.0	893,264.8	292,335.2	75.3
210302	Түлш, халаалт	1,196,288.8	1,088,493.4	107,795.4	91.0
210303	Цэвэр, бохир ус	530,806.3	486,310.7	44,495.6	91.6
210304	Байрны түрээс	10,858,077.6	10,806,860.2	51,217.4	99.5
2104	Хангамж, бараа материалын зардал	2,141,198.0	2,053,891.0	87,307.0	95.9
210401	Бичиг хэрэг	272,826.0	212,184.4	60,641.6	77.8
210402	Тээвэр, шатахуун	927,699.7	883,281.7	44,418.0	95.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	730,186.0	767,218.4	-37,032.4	105.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	210,486.3	191,206.5	19,279.8	90.8
2105	Нормативт зардал	26,036.8	15,618.1	10,418.7	60.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	-	-
210502	Хоол, хүнс	-	-	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	26,036.8	15,618.1	10,418.7	60.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,150,519.7	1,139,586.1	10,933.6	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	460,083.0	481,759.6	-21,676.6	104.7
210602	Тавилга	-	37,130.7	-37,130.7	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	-	-
210604	Урсгал засвар	690,436.7	620,695.8	69,740.9	89.9
2107	Томилолт, зочны зардал	4,132,469.6	4,102,357.3	30,112.3	99.3
210701	Гадаад албан томилолт	3,205,403.6	3,192,651.0	12,752.6	99.6
210702	Дотоод албан томилолт	-	-	-	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	927,066.0	909,706.2	17,359.8	98.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,743,401.7	9,238,421.7	504,980.0	94.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,755,757.2	2,330,156.8	425,600.4	84.6
210803	Даатгалын үйлчилгээ	6,753,302.3	6,714,045.2	39,257.1	99.4
210807	Газрын төлбөр	28,838.8	3,299.0	25,539.8	11.4

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	205,503.4	190,920.7	14,582.7	92.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,241,431.2	2,838,262.4	403,168.8	87.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	338,863.9	160,702.5	178,161.4	47.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,902,567.3	2,677,559.9	225,007.4	92.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	339,824.9	106,736.0	233,088.9	31.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	339,824.9	106,736.0	233,088.9	31.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	339,824.9	106,736.0	233,088.9	31.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,811,400.0	2,803,376.8	8,023.2	99.7
220001	Барилга байгууламж	-	-	-	
221001	Их засвар	1,711,400.0	1,703,609.7	7,790.3	99.5
222001	Тоног төхөөрөмж	1,100,000.0	1,099,767.2	232.8	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,672,332.6	65,031,467.9	-359,135.3	100.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,672,332.6	63,912,301.7	760,030.9	98.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	64,672,332.6	63,912,301.7	760,030.9	98.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.0	1,119,166.2	-1,119,166.2	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	1,119,166.2	-1,119,166.2	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.0	0.0	0.0	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	101,598.4	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,534,437.7	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,041.0	1,041.0	1,041.0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	49.0	49.0	49.0	
610001	Төсвийн байгууллага	49.0	49.0	49.0	
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.0	0.0	0.0	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	496.0	496.0	496.0	
620001	Удирдах ажилтан	49.0	49.0	49.0	
620002	Гүйцэтгэх ажилтан	241	241	241	
620003	Үйлчлэх ажилтан	206	206	206	
620004	Гэрээт ажилтан	-	-	-	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	496	496	496	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	-	-	-	
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	290	290	290	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	206	206	206	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	6,474,519.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,945,683.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,995,667.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	352,160.0
210101	Үндсэн цалин	-	352,160.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	5,600.0
210201	Тэтгэврийн даатгал	-	2,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	192,640.0
210301	Гэрэл, цахилгаан	-	8,400.0
210304	Байрны түрээс	-	184,240.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	18,400.0
210402	Тээвэр, шатахуун	-	4,800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	13,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,400.0
210604	Урсгал засвар	-	4,400.0
2107	Томилолт, зочны зардал	-	36,800.0
210701	Гадаад албан томилолт	-	11,200.0
210702	Дотоод албан томилолт	-	0.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	25,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	114,120.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	104,120.1
210803	Даатгалын үйлчилгээ	-	5,600.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	4,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,271,547.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,261,547.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	10,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	950,015.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	633,333.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	633,333.3
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	316,682.6
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	316,682.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,528,835.8
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,528,835.8
221001	Их засвар	-	50,000.0
222001	Тоног төхөөрөмж	-	1,478,835.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,643,832.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,643,832.4
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,262,897.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,380,935.2
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	169,312.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	169,312.7

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020,03,23	Аудитын нэр: Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/17/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дипломат төлөөлөгчийн газар	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Женев дэх Байнгын төлөөлөгчийн газар нь үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто машиныг ТӨБЗГ-ын 2019 оны 541 дүгээр тогтоолоор данс бүртгэлээс хасаж, худалдан борлуулсны орлого 1,000.0 ам долларын орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй түрээсээр худалдан авах автомашины лизингийн урьдчилгаа төлбөрт зарцуулсан.	2.7		Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
2	ДТГ нь цалин хөлс, нийгмийн даатгалын зардлаас хувь хүний орлогын албан татварт 104.6 сая төгрөгийг Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст, 10.5 сая төгрөгийг Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст тус тус илүү тооцон шилжүүлж, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд авлага нэмэгдүүлсэн.	115.1		Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
3	ДТГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 1,697.0 сая төгрөгийн тооцоо нийлсэн актгүй авлага бүртгэсний 97.3 хувь буюу 1,651.1 сая төгрөг нь 10 жилийн өмнө үүссэн барилгын маргаан болон буцсан ажиллагсадтай холбоотой үүссэн тодорхойгүй авлага бүртгэлтэй байна.			Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
4	ГХЯ нь харьцуулалтын аргаар УБ Сонгодо эмнэлгийг сонгож, гэрээ байгуулан нийт 116 ажилтныг урьдчилан сэргийлэх багц шинжилгээ, үзлэгт хамруулсан боловч нийт 23.2 сая төгрөгийн төлбөрийг төлөхдөө нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас санхүүжүүлсэн.	23.2		Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
5	Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 77.4 хувь буюу 417.4 сая төгрөг нь тайлант				

	хугацаанд үүссэнээс 85.4 сая төгрөг нь Брюссель дэх ЭСЯ-ны барилгын дотоод засал хийлгэх их засварын төлбөр, 43.4 сая төгрөг нь Санфранциско дахь ЭСЯ-ны давсан орлогоос хөрөнгө худалдан бэлтгэсэн төлбөрийн тооцоо бол 125.9 сая төгрөг нь 5 ЭСЯ-ны үнэт цаасны төлбөрийн үлдэгдэл байна.	266.4		Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
6	Гадаад харилцааны яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг нь 2013 онд боловсруулагдсан бөгөөд 2013 оноос хойш өөрчлөгдсөн хууль тогтоомж, Сангийн сайдын баталсан болон бусад батлагдсан заавар журмын өөрчлөлтийг тусгаагүй байна.			Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
7	түлш, шатах тослох материалын үлдэгдэл 31.1 сая төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 9.7 дахин буюу 28.0 сая төгрөгөөр өссөн байна. Дээрх үлдэгдлээс 19.4 сая төгрөг нь Женев дэх Байнгын төлөөлөгчийн газар, 5.6 сая төгрөг нь Бээжин дэх ЭСЯ-ын шатахууны үлдэгдэл бөгөөд тайлант оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж, нөөцөлснөөс шалтгаалсан байна.	28.0		Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
8	ДТГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 43 ДТГ-ын 121 автомашин тайлагнагдсан бөгөөд үүнээс Бээжин дэх ЭСЯ-д 8, Москва дахь ЭСЯ-д 10, Токио дахь ЭСЯ-д 7, Анкара дахь ЭСЯ болон Берлин дэх ЭСЯ-д тус бүр 5, Брюссель дэх ЭСЯ-д 6 автомашин бүртгэлтэй бол бусад ЭСЯ-д 1-4 хүртэлх автомашиныг бүртгэж тайлагнажээ. Нийт 121 автомашин бүртгэлтэйгээс 39 автомашин нь 2500 cc дээш хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжтай байгаа нь ЗГ-ын 2015 оны 184 дүгэр тогтоолтой нийцэхгүй бөгөөд шатахууны зарцуулалт их, сэлбэг хэрэгслийн төлбөр үнэтэй байх нь улсын төсөвт зардал нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.			Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
9	ДТГ-ын кассад 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 507.1 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэл тайлагнагдсанаас 317.8 сая төгрөг нь "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6.1-д "Төсвийн байгууллагын кассанд хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна", 6.2-т "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс хамааран хамгийн ихдээ 1,500.0-3,000.0	317.8		Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа

	мянган төгрөгийн хэмжээтэй байна" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.				
10	Дипломат төлөөлөгчийн газрууд нь Үндэсний аудитын газраас хийсэн элчин шалгалтын аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 1-ний дотор хүргүүлэх байсан боловч хангалтгүй ирүүлсэн, ГХЯ-ны ХҮШДАГ нь уг биелэлтийг гаргуулж, нэгтгэлийг хийж, үнэлээгүй, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн элчин шалгалтаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хянахад нийт 1,497.2 сая төгрөгийн зөрчлийг 85 хувьтай хэрэгжүүлсэн байна	228.7		Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
11	Тайлант онд ДТГ багцын дүнгээр батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч Нью-Йорк дахь БТГ 3.6 мянга, Женев дэх ЭСЯ 17.4 мянга, Парис дахь ЭСЯ 38.6 мянган ам.доллараар буюу нийт 159.0 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлж үйл ажиллагааны орлогоос зарцуулсан байна.	159.0		Төрийн нарийн бичгийн дарга СЭЗХ-ийн захирал	Д.Даваасүрэн Х.Алтантуяа
	Дүн	1,140.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/75

Улаанбаатар хот

САГ-2020/17/СТА-773

Орлого болгох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Женев дэх Байнгын төлөөлөгчийн газар нь үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто машиныг ТӨБЗГ-ын 2019 оны 541 дүгээр тогтоолоор данс бүртгэлээс хасаж, худалдан борлуулсны орлого 1,000.0 ам долларын орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй, түрээсээр худалдан авах автомашины лизингийн урьдчилгаа төлбөрт зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", ТӨБЗГ-ын 2019 оны 541 дүгээр тогтоолыг тус бүр зөрчсөн байна.
2. Дипломат төлөөлөгчийн газар нь цалин хөлс, нийгмийн даатгалын зардлаас хувь хүний орлогын албан татварт 104.6 сая төгрөгийг Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст, 10.5 сая төгрөгийг Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст тус тус илүү тооцон шилжүүлж, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд авлага нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-т "... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага акт өгнө" гэснийг үндэслэн **ТОГТООХ нь:**

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Akt\2020\03255AG1 Docx

001090200

1. Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 117,818,072.22 нэг зуун арван долоон сая, найман зуун арван найман мянга, далан хоёр төгрөг хорин хоёр мөнгийг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 5-ны өдрийн дотор гаргаж ҮАГ-т ирүүлэхийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, СЭЗХ-ийн дарга Х.Алтантуяа, нягтлан бодогч Б.Ууганцэцэг нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
 АУДИТОР *Ц.Наранчимэг*
 АХЛАХ АУДИТОР *П.Чанцалдулам*
 Ц.НАРАНЧИМЭГ
 П.ЧАНЦАЛДУЛАМ
 9006109
 9019120396

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
 ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
 ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
 ДАРГА *Д.Даваасүрэн*
 Д.ДАВААСҮРЭН
 СЭЗХ-ИЙН ДАРГА *Х.Алтантуяа*
 Х.АЛТАНТУЯА
 НЯГТЛАН БОДОГЧ *Б.Ууганцэцэг*
 Б.УУГАНЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25 № 01/165
САГ- 00 20/17/СТА- 773

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 1,697.0 сая төгрөгийн тооцоо нийлсэн актгүй авлага тайлагнагдсаны 97.3 хувь буюу 1,651.1 сая төгрөг нь 10 жилийн өмнө үүссэн тодорхойгүй авлагын үлдэгдэл байна. Үүнд:

- Астана дахь ЭСЯ-д барилга, газрын маргаантай холбоотой 10 жилийн өмнө үүссэн 1,641.5 сая төгрөгийн авлага;
- Берлин дэх ЭСЯ-ны 2013, 2015 онуудад буцсан ажиллагсадтай холбоотой үүссэн 9.6 сая төгрөгийн авлага;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Он удаан жилийн насжилттай авлагын үлдэгдлийг тооцоо нийлэх, барагдуулах, дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж УАГ-т ирүүлэхийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, СЭЗХ-ийн дарга Х.Алтантуяа нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР *[Signature]* П.ЧАНЦАЛДУЛАМ

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ЗӨВШӨӨРСӨН:
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
[Signature] Д.ДАВААСҮРЭН
СЭЗХ-ИЙН ЗАХИРАЛ
[Signature] Х.АЛТАНТУЯА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлөөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/164

Улаанбаатар хот

САГ-2020/17/СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Дипломат төлөөлөгчийн газрын багцын дүнгээр батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч Нью-Йорк дахь Байнгын төлөөлөгчийн газар 3.6 мянга, Женев дэх Элчин сайдын яам 17.4 мянга, Парис дахь Элчин сайдын яам 38.6 мянган ам.доллороор буюу нийт 159.0 /59.6 мянган ам.долларыг 2019 оны валютын дундаж ханш 2663.54/ сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлж үйл ажиллагааны орлогоос зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсөвт багтаан зарцуулалт гаргаж байх, дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж УАГ-т ирүүлэхийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, СЭЗХ-ийн дарга Х.Алтантуяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

П.Чанцалдулам

П.ЧАНЦАЛДУЛАМ

ЗӨВШӨӨРСӨН:

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.Даваасүрэн Д.ДАВААСҮРЭН

СЭЗХ-ИЙН ЗАХИРАЛ

Х.Алтантуяа Х.АЛТАНТУЯА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

